



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2023/157/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Баталгаат тооцоолол аудит ХХК
Захирал: М.Буянбулган
Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaataudit.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

..



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Авхдагчдын өргөө нөмөр 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 117
таныг _____ ны № _____ т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Т.БАЯРБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагуудын дунд Эцэг эхийн зөвлөлийн болзолт уралдаан зохион байгуулж 17 байгууллага ажил дээрээ хүүхдийн өрөөтэй болсон. 2022 оны тавьсан зорилгын хүрээнд хүүхдийн өөрөө удирдах байгууллагыг идэвхжүүлэн ажилласан. ерөнхий боловсролын 22 сургуулийн хэмжээнд 78 өсвөрийн сургагч багш бэлтгэн цахим орчны зөв зохистой хэрэглээ, хүүхдийн оролцоо, эрүүл мэндийн боловсрол сэдвээр өсвөр үеийнхэнд сургалт зохион байгуулсан байна.

0:2chgnawg2023M4tot

→ 006020126

Аудитын гол асуудал

Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар нь 2022 онд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 58 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 93 хувьтай гэж тайлагнасныг төсвийн шууд захирагч 86.0, төсвийн ерөнхийлөн захирагч 91 хувьтай гэж үнэлүүлсэн.

2022 онд тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 394,081.9 мянган, улсын төсвөөс 36,190.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан. 2021 онд хувь хүнээс авах 3,268.9 мянган төгрөгийн авлагатай байсныг бүрэн барагдуулж, 2022 онд түлш халаалтын зардалд 9,085.2 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

D:\bc\cng\neq\2023\44\011

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,308,273.08	19,442,773.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	3,268,900.00	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,268,900.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,039,373.08	19,442,773.08
351	Түүхий эд материал	6,330,700.00	6,330,700.00
35110	Тусгай зориулалттай материал	6,330,700.00	6,330,700.00
354	Хангамжийн материал	12,708,673.08	13,112,073.08
35420	Аж ахуйн материал	12,708,673.08	12,708,673.08
35470	Бусад хангамжийн материал	0.00	403,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	412,706,697.70	362,346,837.84
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	412,706,697.70	362,346,837.84
392	Биет хөрөнгө	392,296,697.70	341,936,837.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	344,617,178.39	344,617,178.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,721,942.26)	(76,282,377.18)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,322,916.78)	(11,260,416.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114,173,917.97	114,173,917.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,114,636.08)	(75,567,757.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,551,219.00	47,742,189.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,831,122.54)	(26,430,896.26)
39217	Ном	1,445,000.00	1,445,000.00
393	Биет бус хөрөнгө	20,410,000.00	20,410,000.00
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.00)	(500,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,410,000.00	20,410,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	435,014,970.78	381,789,610.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	9,085,218.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	9,085,218.92
413	Өглөг	0.00	9,085,218.92
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	9,085,218.92
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	435,014,970.78	372,704,392.00
51	Засгийн газрын хувь оролцоо	435,014,970.78	372,704,392.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108,611,173.00	108,611,173.00
512	Хуримтлагдсан үр дүн	161,538,333.35	99,227,754.57
51210	Өмнөх үеийн үр дүн	161,538,333.35	161,538,333.35
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(62,310,578.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164,865,464.43	164,865,464.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	435,014,970.78	381,789,610.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	356,491,900.00	431,866,950.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,399,600.00	395,676,270.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,399,600.00	1,594,370.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	0.00	5,848,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	325,092,300.00	36,190,680.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	122,131,700.00	36,190,680.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139,255,300.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,705,300.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	362,462,924.00	494,177,528.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,462,924.00	494,177,528.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,351,508.26	470,255,161.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,625,760.00	155,310,680.56
210101	Үндсэн цалин	115,163,667.00	121,992,059.56
210102	Нэмэгдэл	18,462,093.00	11,889,590.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	9,535,334.00
210104	Урамшуулал	0.00	11,893,697.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,213,602.26	19,750,732.92
210201	Тэтгэврийн даатгал	13,338,137.58	13,516,824.43
210202	Тэтгэмжийн даатгал	1,237,791.17	1,590,214.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	970,152.90	1,245,291.51
210204	Ажилгүйдлийн даатгал	242,438.27	308,945.78
210205	Эрүүл мэндийн даатгал	2,425,082.34	3,089,456.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,205,300.00	88,976,718.92
210301	Гэрэл, цахилгаан	2,700,208.43	2,689,960.92
210302	Түлш, халаалт	57,785,300.00	83,071,758.00
210303	Цэвэр, бохир ус	1,719,791.57	3,215,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,818,440.00	2,914,640.00
210401	Бичиг хэрэг	1,369,250.00	520,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,327,430.00	820,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,121,760.00	1,362,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	211,300.00
2105	Нормативт зардал	0.00	9,825,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	840,000.00	608,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	188,300.00
210604	Урсгал засвар	840,000.00	420,200.00
2107	Томилолт, зочны зардал	544,000.00	210,100.00
210702	Дотоод албан томилолт	544,000.00	210,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,670,082.00	137,030,569.50

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,211,465.00	136,766,004.50
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,265.00	101,265.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	43,700.00
210807	Газрын төлбөр	55,352.00	75,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,434,324.00	55,627,469.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,109,200.00	3,268,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,869,900.00	807,740.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,455,224.00	51,550,829.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,111,415.74	23,922,367.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	10,441,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	10,441,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,111,415.74	13,480,967.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,111,415.74	13,480,967.02
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(5,971,024.00)	(62,310,578.78)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(5,971,024.00)	(62,310,578.78)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	334,627,300.00	430,272,580.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	394,081,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	0.00	388,233,900.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	0.00	5,848,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	334,627,300.00	36,190,680.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	122,131,700.00	36,190,680.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	36,190,680.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	122,131,700.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,790,300.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	148,790,300.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,705,300.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,705,300.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	334,627,300.00	430,272,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,627,300.00	430,272,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	329,515,884.26	406,350,212.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,625,760.00	155,310,680.56
210101	Үндсэн цалин	115,163,667.00	121,992,059.56
210102	Нэмэгдэл	18,462,093.00	11,889,590.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	9,535,334.00
210104	Урамшуулал	0.00	11,893,697.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,213,602.26	19,750,732.92
210201	Тэтгэврийн даатгал	13,338,137.58	13,516,824.43
210202	Тэтгэмжийн даатгал	1,237,791.47	1,590,214.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	970,152.90	1,245,291.51
210204	Ажилгүйдлийн даатгал	242,437.97	308,945.78
210205	Эрүүл мэндийн даатгал	2,425,082.34	3,089,456.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,205,300.00	79,891,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,700,208.43	2,689,960.92
210302	Түлш, халаалт	57,785,300.00	73,986,539.08
210303	Цэвэр, бохир ус	1,719,791.57	3,215,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,697,850.00	2,914,640.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	520,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,197,850.00	820,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,362,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	211,300.00
2105	Нормативт зардал	0.00	9,825,750.00
210502	Хоол, хүнс	0.00	9,825,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	608,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	188,300.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	420,200.00
2107	Томилолт, зочны зардал	544,000.00	210,100.00
210702	Дотоод албан томилолт	544,000.00	210,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,756,472.00	137,030,569.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,297,855.00	136,766,004.50
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,265.00	101,265.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	43,700.00
210807	Газрын төлбөр	55,352.00	75,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,972,900.00	807,740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,320,800.00	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,652,100.00	807,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,111,415.74	23,922,367.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	10,441,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	10,441,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,111,415.74	13,480,967.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,111,415.74	13,480,967.02
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	108,611,173.00	164,865,464.43	161,538,333.35	435,014,970.78
D02	2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	108,611,173.00	164,865,464.43	161,538,333.35	435,014,970.78
D03	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D04	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,611,173.00	164,865,464.43	161,538,333.35	435,014,970.78
D05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D07	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D08	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D09	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(62,310,578.78)	(62,310,578.78)
D010	2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	108,611,173.00	164,865,464.43	99,227,754.57	372,704,392.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	388,233,900.00	388,233,900.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	388,233,900.00	388,233,900.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,792,500.00	364,311,532.98	96.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167,359,700.00	155,310,680.56	92.80
210101	Үндсэн цалин	140,299,600.00	121,992,059.56	86.95
210102	Нэмэгдэл	27,060,100.00	11,889,590.00	43.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	9,535,334.00	0.00
210104	Урамшуулал	0.00	11,893,697.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,920,000.00	19,750,732.92	94.41
210201	Тэтгэврийн даатгал	14,055,200.00	13,516,824.43	96.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,716,200.00	1,590,214.57	92.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,373,000.00	1,245,291.51	90.70
210204	Ажилгүйдлийн даатгал	343,200.00	308,945.78	90.02
210205	Эрүүл мэндийн даатгал	3,432,400.00	3,089,456.63	90.01

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,891,500.00	79,891,500.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,593,400.00	2,689,960.92	74.86
210302	Түлш, халаалт	72,810,800.00	73,986,539.08	101.61
210303	Цэвэр, бохир ус	3,487,300.00	3,215,000.00	92.19
2104	Хангамж, бараа материалын зардал	2,915,400.00	2,914,640.00	99.97
210401	Бичиг хэрэг	520,400.00	520,400.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	821,500.00	820,740.00	99.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,362,200.00	1,362,200.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	211,300.00	211,300.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	608,500.00	608,500.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	188,300.00	188,300.00	100.00
210604	Урсгал засвар	420,200.00	420,200.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	210,100.00	210,100.00	100.00
210702	Дотоод албан томилолт	210,100.00	210,100.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,074,200.00	104,817,639.50	99.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,622,200.00	104,553,074.50	99.93
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	101,265.00	40.51
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	44,000.00	29.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	52,000.00	43,700.00	84.04
210807	Газрын төлбөр	0.00	75,600.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	813,100.00	807,740.00	99.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	813,100.00	807,740.00	99.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,441,400.00	23,922,367.02	229.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,441,400.00	10,441,400.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	10,441,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,441,400.00	0.0	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг	0.00	13,480,967.02	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	13,480,967.02	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,038,680.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,038,680.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,038,680.00
2105	Нормативт зардал	9,825,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00
210502	Хоол, хүнс	9,825,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,212,930.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,212,930.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагуудын дунд Эцэг эхийн зөвлөлийн болзолт уралдаан зохион байгуулж 17 байгууллага ажил дээрээ хүүхдийн өрөөтэй болсон. 2022 оны тавьсан зорилгын хүрээнд хүүхдийн өөрөө удирдах байгууллагыг идэвхжүүлэн ажилласан. ерөнхий боловсролын 22 сургуулийн хэмжээнд 78 өсвөрийн сургагч багш бэлтгэн цахим орчины зөв зохистой хэрэглээ, хүүхдийн оролцоо, эрүүл мэндийн боловсрол сэдвээр өсвөр үеийнхэнд сургалт зохион байгуулсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар нь 2022 онд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 58 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 93 хувьтай гэж тайлагнасныг төсвийн шууд захирагч 86.0, төсвийн ерөнхийлөн захирагч 91 хувьтай гэж үнэлсэн.

2022 онд тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 394,081.9 мянган, улсын төсвөөс 36,190.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан. 2021 онд хувь хүнээс авах 3,268.9 мянган төгрөгийн авлагатай байсныг бүрэн барагдуулж, 2022 онд түлш халаалтын зардалд 9,085.2 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль

- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" дотоод журмын заалтыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг УСНББОУС-т заасан зарчмын дагуу санхүүгийн тайланг гаргахдаа нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн. Мөн Сангийн сайдын 32 дугаар тушаал, Санхүү эдийн засгийн сайдын 253 дугаар, Сангийн сайдын 353 дугаар тушаалын нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг Си Ти Эс програм хангамж ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,225.4 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	3,268.9	0.0	-3,268.9
Бараа материал	19,039.4	19,442.8	403.4
Үндсэн хөрөнгө	412,706.7	362,346.8	-50,359.9
Нийт хөрөнгө	435,015.0	381,789.6	-53,225.4
Өр төлбөр		9,085.2	9,085.2

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	435,015.0	372,704.4	-62,310.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	435,015.0	381,789.6	-53,225.4

Хүснэгтээс дэх 2022 оны мэдээллийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж гарсан өөрчлөлтийг судлан үзэхэд бараа бусад хангамжийн үнэгүй авсан 403.4 мянган төгрөгийн барааны дүнгээр өсч, үндсэн хөрөнгө тайлант онд 51,550.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулагдсан нь 50,359.9 мянган төгрөгөөр буурахад хүргэсэн байна.

Тайлант онд хувь хүмүүсээс авах авлагаа бүрэн барагдуулсан боловч түлш халаалтад 9,085.2 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төслийг санхүүжүүлэлтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 250,4 сая, үйл ажиллагааны орлогоос 35.0 сая, нийт зарлагыг 285.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 81.7 сая төгрөгөөр бууруулж, 203.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 21.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 172.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 36.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна.

Зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 99.8 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн дэлгэрэнгүйг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 42,038.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан ба тайлангийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөлүүдийг тусгасан болно.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган нар хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улсын төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогын 388,000.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,820,0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эд хогшил, урсгал засварын зардлыг 56.3 хувь буюу 4,359.7 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйчилгээний зардлыг 13.0 хувь буюу 178.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус газар 2022 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь байршуулж, мэдээлээгүй 2, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн тухай 78 тушаал мэдээллэхээс 12,223.1 мянган төгрөгийн дүнтэй А тушаал 7, Б тушаал 4-ийг орхигдуулсныг аудитын баг албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12-р сарын 8-нд цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээллийг авч танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 2022 оны 6 дугаар сарын 22-нд 01/115 тоотор биелэлтээ Булган аймаг дахь ТАГ-т хүргүүлжээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	3.4	2	3.4	100
Нийт дүн	3	3.4	3	3.4	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар өгсөн зөвлөмж, түүний хэрэгжилтийг завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 13,817.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,594.4 мянган төгрөгийн алдааг залруулж, эрх зүйн акт зөрчигдсөн² 3 алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгхөөр аудитын баг шийдвэрлэсэн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар Шилэн дансны хууль, журмыг мөрдлөг болгон ажиллах талаар албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Жилийн эцсийн бараа материалын үлдэгдлийг тооллогын комиссын бүртгэлээр бус нярвын тайланг үндэслэл болгосон.
2. Тайланд үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгө, бусад хангамжийн материалыг буруу ангилж бүртгэсэн.
3. Алдаа зөрчилтэй анхан шатны баримтыг хүлээн зөвшөөрсөн.

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт 2022 оны жилийн эцсийн бараа материалын үлдэгдлийг тооллогын комиссын бүртгэлээр бус нярвын тайланг баталгаажуулсан баримтаар тайлагнасныг байгууллагын удирдлагуудад танилцуулсан. Байгууллага аудитын шалгалтын хугацаанд комиссын бүрэлдэхүүнийг дахин ажиллуулж зөрчлийг арилгаж тайлагнах саналыг аудитын багт тавьж, аудитын хугацаанд шийдвэрлэсэн. Алдаа, зөрчлийн асуудлыг баримтжуулсан. Энэ нь ТБОНӨТХ-ийн 72 дугаар зүйлийн 4.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4, 20.2.6 заалт

Санхүүгийн тайлангийн толилуулга УСНББОУС1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 15.1, 15.2, 20.2.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.16, 4.33 заалтыг мөрдлөг болгоогүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн актуудыг мөрдлөг болгож ажиллах

2. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт Тайланд үнэ төлбөргүй шилжүүлж авсан үндсэн хөрөнгийн 1,191.0 мянган, бусад хангамжийн материалын 403.4 мянган төгрөгийн орлого нийт 1,594.4 мянган төгрөгийн хөрөнгийг орлогын зүйлийг худалдан авснаар илэрхийлсэн. Санхүүгийн тайлангийн толилуулга УСНББОУС1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 15.1, 15.2,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

20.2.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.16, 4.33 заалтыг мөрдлөг болгоогүй.

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн актуудыг мөрдлөг болгож, дансны бичилтийг үнэн зөв бүртгэх

3. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтыг шалгахад жолоочийн тооцооны хуудас дахь хэрэглэгчийн гарын үсэг дутуу, явсан км-ыг нийт хэмжээгээр тэмдэглэсэн байв. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн ААН, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын Зургаагийн 4 заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Залруулга	1	1,594.4					1	1,594.4			1	1,594.4
Эрх зүйн актыг мөрдөөгүй	2	0.0			1	0.0			2	0.0	2	0.0
Дүн	3	1,594.4			1	0.0	1	1,594.4	2	0.0	1	1,594.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрх зүйн актыг мөрдөөгүй	3	13,817.5			1	12223.1	2	1594.4				
Дүн	3	13,817.5			1	12223.1	2	1594.4				